

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

11.23 - 11.27



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: Амралтын өдөр таарсан энэ долоо хоногт хөрөнгө оруулагчид коронавирусын эсрэг вакцинтай холбоотой эерэг хүлээлттэй байгаа болон улс төрийн тогтворгүй байдал буурч байгаа нь АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүдийг өсөлттэй байхад нөлөөлжээ. АНУ-ын хөрөнгийн зах зээлийн гол индексүүд бүгд өсөлттэй байсан ба ялангуяа Dow Jones индекс анх удаагаа 30,000 нэгжийг давсан байна. Хөл хорио цуцлагдан, эдийн засаг эргэн нээгдэж эхлэх хүлээлттэй холбоотой эдийн засгийн мөчлөгтэй уялдаатай компаниудын хувьцаа өсөлттэй байсан ба эрчим хүчний салбар хамгийн их өсөлттэй байлаа. Харин эрүүл мэнд, ус, цахилгаан, дулааны хангамж, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн болон үл хөдлөх хөрөнгийн салбар хамгийн их уналттай байлаа. Пүрэв гарагт "Талархлын Баяр" болж АНУ-ын хөрөнгийн зах зээл хаалттай байсан ч долоо хоногийн арилжааны хэмжээ их байлаа.

Европ: Вакцинтай холбоотой эерэг хүлээлт, АНУ-ын улс төрийн байдал болон АНУ-ын Конгресс эдийн засгийн сэргээх хөтөлбөр батлах магадлалтай байгаагаас үүдэн Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд энэ долоо хоногт дахин өсөлт үзүүлээ. Гэхдээ Их Британи болон ХБНГУ хөл хорионы арга хэмжээгээ сунгах шийдвэр гаргасантай холбоотой өсөлт удааширсан байна. STOXX Europe 600 индекс 0.93%-аар, DAX индекс 1.51%-аар, CAC 40 индекс 1.86%-аар, FTSE MIB индекс 2.92%-аар, FTSE 100 индекс 0.25%-аар тус тус өссөн байна.

Энэ долоо хоногт Евробүсийн голлох бондуудын өгөөж хэлбэлзэл ихтэй байсан ч өгөөжүүд Даваа гарагийн үеийн түвшинд хаагдсан байна. Долоо хоногийн эхэнд вакцинтай холбоотой эерэг мэдээллээс үүдэн ХБНГУ-ын 10 жилийн хугацаатай ЗГҮЦ-ны өгөөж нэмэгдэж байсан ч Европын Төв Банкнаас дахин эдийн засгийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх тухай мэдээлэл гарснаар өгөөж эргэн буурсан байна.

Япон: Энэ долоо хоногт Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. Даваа гарагт амралтын өдөр байсан тул Япон улсын хөрөнгийн зах зээл хаалттай байлаа. Nikkei 225 индекс 1,172 нэгжээр буюу 4.38%-аар өсөж 26,644.71 нэгж хүрсэн нь энэ сарын эхэн үетэй харьцуулахад 16%-аар өссөн үзүүлэлт болсон ба 1991 оны 4-р сараас хойших хамгийн өндөр түвшин юм. Япон улсын хөрөнгийн зах зээлийг бүхэлд нь илтгэдэг large-cap TOPIX болон TOPIX small индексүүд мөн өсөлттэй байлаа. Иений ам.доллартой харьцах ханш чангарч, Баасан гараг гэхэд ам.доллар 104 иен хавьцаа арилжаалагдаж байв.

БНХАУ: Дотоод зах зээлд гаргасан бондууд дефолт зарлаж эхэлсэн ч эдийн засгийн үзүүлэлтүүд хүлээлтээс эерэг гарсантай холбоотой БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй байлаа. CSI 300 индекс 0.8%-аар, Shanghai Composite индекс 0.9%-аар тус тус өссөн байна.

БНХАУ-ын гадаад зах зээлд гаргасан 10 жилийн хугацаатай ЗГҮЦ-ны өгөөж болон ам.долларын эсрэг юанийн ханш тогтвортой байлаа. Мөн БНХАУ-ын өндөр хүүтэй бондын зах зээл дээр дефолтууд огцом өсөж эхэлсэн нь БНХАУ-ын эрх баригчид ойрын хугацаанд эдийн засгийг цаашид идэвхжүүлэх биш харин бизнесийн салбарт хөшүүргийн хэмжээг бууруулах арга хэмжээ авч эхэлнэ гэх хүлээлтийг төрүүлж эхэлжээ.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	17,550.05	-0.20% ▼
Dow Jones	АНУ	29,910.37	2.21% ▲
S&P 500	АНУ	3,638.35	2.27% ▲
Nasdaq	АНУ	12,205.85	2.96% ▲
S&P/TSX	Канад	17,396.56	2.22% ▲
FTSE 100	Их Британи	6,367.58	0.25% ▲
S&P/ASX 200	Австрали	6,601.10	0.95% ▲
Nikkei 225	Япон	26,644.71	4.38% ▲
Hang Seng	Хонг Конг	26,819.45	1.39% ▲

Бонд	Валют	Купон	Өгөөж
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	3.50%
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	3.24%
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	3.05%
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	1.41%
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	1.08%
DBM' 2023	USD	7.250%	4.43%
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	9.55%
Mongol 2026 (Номад)	USD	5.125%	3.85%

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.155	0.00 ▲
Libor 3M	0.225	0.02 ▲
Libor 6M	0.257	0.01 ▲
Libor 1YR	0.330	-0.01 ▼
US 2YR Bond	0.152	-0.01 ▼
US 3YR Bond	0.194	-0.02 ▼
US 5YR Bond	0.366	-0.01 ▼
US 10YR Bond	0.836	0.01 ▲

Валютын ханш	2020.11.27	Өөрчлөлт
USD	2,849.51	0.02% ▲
CNY	432.91	-0.07% ▼
EUR	3,398.90	0.61% ▲
RUB	37.56	-0.11% ▼
KRW	2.58	0.78% ▲
JPY	27.38	0.33% ▲
CAD	2,190.25	0.26% ▲

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,787.79	-4.45% ▼
Мөнгө /спот/	USD/t oz.	22.57	-6.63% ▼
Зэс	USD/lb.	341.75	3.25% ▲
Нүүрс	USD/MT	68.75	5.20% ▲
WTI газрын тос	USD/bbl.	45.53	8.02% ▲
Brent газрын тос	USD/bbl.	48.18	7.23% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020.X	2.40%
Бодлогын хүү	2020.X	8.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020.X	7.67%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020.X	10.65%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020.X	3.83%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020.X	16.82%
Зээлийн дундаж хүү /валют/	2020.X	10.47%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg


МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 44 компанийн 168.9 сая төгрөгийн 743,559 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Мерекс” /MSE: MRX/ компанийн хувьцаа 21.74%-аар буюу хамгийн ихээр өсөж 28.00 төгрөг хүрч хаагдсан бол “Нако түлш” /MSE: NKT/ компанийн хувьцаа 10.71%-аар буурч 25.00 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт компанийн бондын анхдагч болон хоёрдогч зах зээл мөн ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

11-р сарын 27-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,585.3 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 индекс 17,550.05 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.20% -аар буурсан байна.



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн тойм

Арилжигдсан үнийн дүн	Дүн (сая.төг)
Арилжигдсан үнийн дүн	168.9
Зах зээлийн үнэлгээ	2,585,287.9

Зах зээлийн индексүүд

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	17,550.05	-0.20% ▼
MSE I индекс	8,080.50	0.37% ▲
MSE II индекс	7,376.81	0.25% ▲

Идэвхтэй арилжагдсан хувьцаа

Хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
МИК холдинг	5,064	55,704,000
АПУ	69,925	40,691,410
Эрдэнэ ресурс девелопмент корп	20,293	17,255,491
Ногоон хөгжил үндэсний нэгдэл	91,008	9,498,570
Мандал даатгал	180,305	8,710,531

Өсөлттэй хувьцаа

Хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Мерекс	28.00	21.74% ▲
Хөх ган	63.00	14.55% ▲
Түшиг уул	820.00	13.89% ▲
Оллоо	45.10	11.41% ▲
Ариг гал	2,800.00	10.02% ▲

Бууралттай хувьцаа

Хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Нако түлш	25.00	-10.71% ▼
Нэхээсгүй эдлэл	1,750.00	-7.89% ▼
Улсын их дэлгүүр	1,210.00	-6.92% ▼
Адуун чулуун	850.69	-5.58% ▼
Улаанбаатар хивс	17,000.00	5.56% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК

ҮЦК	Дүн (төг)
Ард Секюритиз	110,759,954
БиДиСек	91,265,236
Апекс Капитал	32,389,536
Ти Ди Би Капитал	26,685,582
Стандарт Инвестмент	21,049,919

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт (төг)	33Ү (сая.төг)
АПУ	574.61	611,489.36
Таван толгой	6,035.00	317,834.48
МИК холдинг	11,000.00	227,802.52
Инвекор ББСБ	2,900.00	208,010.96
Говь	192.30	150,015.63

Компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаа

№	ҮНЭТ ЦААСНЫ НЭР	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

“Хот девелопмент” /MSE: SDT/ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд.

“Хот девелопмент” / MSE: SDT/ ХК-ийн 2020 оны 11-р сарын 20-ны өдрийн ТУЗ-ийн хурлын №20/06 тоот шийдвэрээр тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2021 оны 1-р сарын 4-ний өдрийн 10:00 цагт хуралдуулахаар товлосон байна.

Хурал хуралдах огноо: 2021 оны 1-р сарын 4-ний өдрийн 10:00 цагт

Бүртгэх өдөр: 2020 оны 12-р сарын 11-ний өдөр

Хуралдах газар: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө 27/1 “Би Ди Сек” ҮЦК ХК-ийн төв байр. /Коронавирусын цар тахалтай холбогдуулан гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн тохиолдолд онлайн хурлыг зохион байгуулна/

Хурлаар хэлэлцэх асуудал:

- Компанийн өрийг хувьцаагаар солих төслийг батлах тухай.
- Компанийн өрийг хувьцаагаар солихтой холбогдуулан хаалттай хүрээнд нэмж энгийн хувьцаа гаргах тухай.
- Компанийн өрийг хувьцаагаар солихтой холбоотой сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийг хэлэлцэн батлах тухай.
- Компанийн өрийг хувьцаагаар солихтой холбогдуулан хаалттай нэмж гаргаж буй хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэх эсэх тухай.

Хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам:

Хурлын материал, гарах шийдвэрийн төсөл болон холбогдох баримт бичигтэй ажлын өдрүүдэд 09.00-17.00 цагийн хооронд “БиДиСек” ҮЦК-ийн төв оффис болон хурал зохион байгуулах комиссын дарга Х.Азбаяр, гишүүн Э.Эрхэмзаяа нараас холбогдох мэдээллийг цахимаар авч, танилцах боломжтой.

Хурал зохион байгуулах комисс: 75551919, 99052845

Имэйл хаяг: info@bdsec.mn

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Эрдэнэ ресурс девелопмент корпораци” /TSX ERD, MSE: ERDN/ ХК хувьцаа худалдан авах эрхийн хугацаагаа сунгалаа.

“Эрдэнэ ресурс девелопмент корпораци” /TSX: ERD, MSE: ERDN/ ХК (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани”) нь 2018 оны 6-р сард хаагдсан хаалттай санхүүжилтийн хүрээнд гаргасан 11,314,580 энгийн хувьцаа худалдан авах эрх бүхий варрант (“Варрант”)–ын хугацааг сунгахаар болсныг мэдээлжээ. 2020 оны 12-р сарын 8-ны өдрөөс эхлэн эдгээр варрантын хүчинтэй хугацааг гурван сараар буюу 2021 оны 3 сарын 8-ны өдөр хүртэл сунгасан. Варрантыг хэрэгжүүлэх 0.6 ам.долларын үнэ болон бусад нөхцөлүүд өөрчлөгдөхгүй.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Эрдэнэ ресурс девелопмент корпораци” /TSX ERD, MSE: ERDN/ ХК өрөмдлөгийн хөтөлбөрөөр Баян Хөндий алтны ордын залгаа хэд хэдэн талбай дахь алтны эрдэсжилтийг тэллээ.

“Эрдэнэ ресурс девелопмент корпораци” /TSX: ERD, MSE: ERDN/ ХК (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани”) нь Хөндий Алтны Дүүрэгт төлөвлөсөн 18,000 метрийн өрөмдлөгийн хөтөлбөрийн эхний үе шатны 10,000 метр хөтөлбөрийн эцсийн үр дүнг тайлагнан, Баян Хөндий ордтой залгаа хэд хэдэн талбайд өндөр агуулга бүхий алтны эрдэсжилтийг тэлснийг мэдээлжээ.

Онцлох мэдээлэл:

- Баян Хөндий ордоос баруун зүгт 200 метрт Баруун Страйкер талбайд шинээр өндөр агуулга бүхий алтны интервал огтолсон:
 1. ВКД-334: 4.5 г/т алтны агуулга бүхий 14 метр интервалд 36.9 г/т алтны агуулга бүхий 1 метр багтсан бөгөөд энэ нь 2.5 г/т алтны агуулга бүхий 28 метр интервалд багтаж байна.
 2. ВКД-338: 5.5 г/т алтны агуулга бүхий 9 метр интервалд 23.3 г/т алтны агуулга бүхий 1 метр багтсан бөгөөд энэ нь 1.8 г/т алтны агуулга бүхий 38 метр интервалд багтаж байна.
 3. ВКД-339: 13.1 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервал багтаасан 1.2 г/т алтны агуулга бүхий 54 метрийн интервал огтолсон.
- Баруун Страйкер бүс өмнө зүгт болон гүндээ үргэлжилж байгааг тогтоолоо (ВКД-266):
 1. ВКД-341: 17.0 г/т алтны агуулгатай 1 метрийн интервал багтаасан 4.7 г/т алтны агуулга бүхий 4 метрийн интервал огтолсон.
- Ордын өмнө ба зүүн зүгт Өмнөд Страйкер талбайд газрын гадаргад ойр, өндөр агуулгыг тэллээ:
 1. ВКД-315: 37 метрийн гүнээс эхлэн 14.0 г/т алтны агуулга бүхий 1 метр багтаасан 5.0 г/т алтны агуулга бүхий 3 метрийн интервал огтолсон.
 2. ВКД-316: 13 метрийн гүнээс эхлэн 21.7 г/т алтны агуулга бүхий 1 метр багтаасан 4.7 г/т алтны агуулга бүхий 5 метрийн интервал огтолсон.
- Зүүн Өмнөд Мидфийлд талбайн 200 метр структурын дагуу алтны эрдэсжилт үргэлжилж байна:
 1. ВКД-319: 2.8 метрийн гүнээс эхлэн, 14.5 г/т болон 28.9 г/т алтны агуулга бүхий 1 метр агуулсан 2.9 г/т алтны агуулга бүхий 18.2 метрийн интервал огтолсон.
 2. ВКД-322: 3 метрийн гүнээс эхлэн 23.5 г/т алтны агуулга бүхий 1 метр агуулсан 5.2 г/т алтны агуулга бүхий 7 метрийн интервал огтолсон.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

Бүх нийтийн бэлэн байдалд шилжүүлсэнтэй холбоотой 12-р сарын нэгний өдөр хүртэл тогтоосон хатуу хөл хорионы улмаас улсын хэмжээнд аж ахуйн нэгжүүд 152.9 мянган ажлын байр цөөлснийг МҮХАҮТ-ын судалгаанд дурджээ.

Хатуу хөл хориог 12-р сарын 31-ний өдөр хүртэл нэг сараар сунгахад 432.6 мянга, 3-р сарын нэгэн хүртэл сунгахад 505 мянган ажлын байр цөөлөх төлөвтэй байна. Нийт аж ахуйн нэгжүүдийн 66 хувь нь бүрэн зогссон бөгөөд 53 хувь нь одоо байгаа нөөц бололцоогоороо ажлын байраа нэг сараас илүү хугацаанд хадгалж чадахгүй гэжээ.

Эх сурвалж: BloombergTV.mn

МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Fitch: Монголын банкнуудын активын чанарын асуудлыг шийдэх хугацаа улам хойшилж магадгүй

Цар тахлын үед зарим зээлийн төлбөрийг хойшлуулах арга хэмжээ авч байгаа нь Монголын банкуудын активын чанарын асуудлыг шийдэх хугацааг улам хойшлуулж магадгүй гэж "Fitch" агентлаг мэдэгдлээ.

Монголбанкны мэдээллээр 9-р сарын байдлаар нийт зээлийн 22 хувьд буюу 3.8 их наяд төгрөгийн зээлд бүтцийн өөрчлөлт оруулаад байгаа юм. Ингэхдээ зээлийн ангилалд ямар нэг өөрчлөлт оруулахгүй байхаар зохицуулалт хийжээ. 22 хувь гэсэн энэ үзүүлэлт оны эцэст 30 хувьд хүрч магадгүй гэж "Fitch" тооцоолж байна.

Үүнээс гадна Монгол Улсын эдийн засгийг 2021 онд найман хувиар өснө гэж тус агентлаг үзэж байна. Цар тахлаас үүдэлтэй сөрөг нөлөө, ялангуяа активын чанар болон ашигт ажиллагаанд үзүүлэх нөлөөг Монголын банкууд Эрсдэлийн сандаа төвлөрүүлсэн хөрөнгөөрөө ерөнхийд нь хааж чадна гэж дүгнэжээ.

Эх сурвалж: BloombergTV.mn

Мөнгөний бодлогын мэдэгдэл.

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо КОВИД-19 цар тахал дотоодод тархаж, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж хөл хорио тогтоосонтой холбоотойгоор 2020 оны 11-р сарын 23-ны өдөр ээлжит бусаар хуралдлаа. Энэхүү хуралдаанаар:

1. Бодлогын хүүг 2 нэгж хувиар бууруулж 6 хувьд хүргэх;
2. Банкны төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 2.5 нэгж хувиар бууруулж 6 хувьд тогтоох;
3. Эргэн төлөлт нь доголдсон хэрэглээний зээлд бүтцийн өөрчлөлт хийж, хугацааг сунгах арга хэмжээг 2021 оны 7-р сарын 1-ний өдрийг хүртэл үргэлжлүүлэн хэрэгжүүлэх;
4. Жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортыг дэмжихэд зориулсан урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслийг нэвтрүүлэх багц шийдвэрийг гаргалаа.

Энэ нь КОВИД-19 цар тахлын үед эдийн засаг, банк, санхүүгийн салбарт үүсч буй сөрөг нөлөөг бууруулах, иргэд, бизнес эрхлэгчид, санхүүгийн байгууллагуудад тулгарч буй санхүүгийн хүндрэл дарамтыг зөөлрүүлэхэд чиглэж байна. Түүнчлэн дунд хугацаанд инфляцын зорилтыг алдагдуулахгүйгээр санхүүгийн болон эдийн засгийн тогтвортой байдлыг дэмжинэ.

Жилийн инфляц 2020 оны 10-р сард улсын хэмжээнд 2.4 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 2.6 хувьд хүрэв. Ирэх саруудад инфляц суурь үеийн нөлөөгөөр бага зэрэг нэмэгдэх хэдий ч, эдийн засгийн идэвхжлээс шалтгаалан бага түвшинд хадгалагдаж зорилтот түвшнээс давахааргүй байна. Эдийн засаг "КОВИД-19" цар тахлын нөлөөгөөр 2020 оны эхний хагаст 9.7 хувиар агшсан бол 3-р улиралд уналт -3.1% болон саармагжиж, төлбөрийн тэнцлийн төсөөлөл сайжрав. Цар тахлын дотоод тархалтыг хумихаар 11-р сард тогтоосон хөл хорионы арга хэмжээнүүд нийгмийн эрүүл мэндийг хамгаалж, дунд урт хугацаанд эерэг нөлөөтэй боловч богино хугацаанд эдийн засгийн үйл ажиллагааг хумьснаар сэргэлт удаашрах төлөвтэй байна.

Дэлхийн эдийн засгийн идэвхжил 2020 оны сүүлийн хагаст сэргэж буйг бодит эдийн засаг, санхүүгийн зах зээл, түүхий эдийн захын үзүүлэлтүүд илэрхийлж байна. Эхний вакцинуудын амжилттай туршигдан дуусах шатандаа орж буй хэдий ч цөөнгүй улс оронд вирусийн хоёр дахь болон гурав дахь давлагаа үргэлжилж, эдийн засгийн цаашдын төлөвийн тодорхой бус байдал өндөр хэвээр байна.

"КОВИД-19" цар тахлын сөрөг нөлөөг бууруулах зорилгоор шат дараатай авч хэрэгжүүлж буй мөнгөний болон макро зохистой бодлогын арга хэмжээнүүд нь жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортын санхүүжилтийг нэмэгдүүлж, санхүүжилтийн өртгийг бууруулан дотоод эдийн засгийн уналтыг сааруулах, банкны салбарын тогтвортой байдлыг хадгалахад дэмжлэг үзүүлнэ. Монголбанк нь өрхийн болон аж ахуйн нэгжийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжихийн зэрэгцээ банкны системийн зээлийн тасалдал үүсэхээс сэргийлсэн зохистой арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Эх сурвалж: Монголбанк

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Зэсийн эрэлт өсөх төлөвтэй болж, тонн нь 7,300 ам.доллар давлаа.

Зэсийн үнэ мягмар гарагт сүүлийн зургаан жилийн дээд түвшинд хүрч хаагдлаа. Энэхүү түүхий эдийн үнэ сүүлийн найман сар дараалан өсөж байна.

Өөрөөр хэлбэл өсөлт нь 2011 оноос хойш хамгийн урт хугацаанд үргэлжилж байгаа юм. Эдийн засгийн гол барометр болдог зэсийн үнэ өсөлттэй байгаа нь БНХАУ-д хэрэглээ эрчимтэй сэргэж, нийлүүлэлт хумигдаж байгаатай холбоотой аж. Үүн дээр нэмээд “коронавирус”-ийн вакцин гарч, дэлхийн эдийн засгийн өсөлт сэргэх төлөв давамгайлж байгаа нь үнэд эергээр нөлөөлж байна.

Нөгөө талаас БНХАУ-ын Төрийн тэргүүн болон АНУ-ын шинээр сонгогдсон Ерөнхийлөгч Жо Байден нарын “Ногоон хөгжлийн санаачилга” зэсийн эрэлтийг дэмжихээр байна. Цахилгаан автомашин болон сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэлд ихээр шаардагддаг гэдэг утгаараа зэсийн эрэлт ирэх жилүүдэд нэмэгдэх төлөв давамгайлж байгаа юм.

Лхагва гарагийн өглөөний байдлаар зэсийн фьючерс үнэ тонн нь 7,307.5 ам.доллар болоод байна.

Эх сурвалж: BloombergTV.mn

Sxcoal: Жолооч нар “COVID-19”-ийн шинжилгээний бичгийг хуурамчаар бүрдүүлсэн тохиолдол гарсан.

Гашуунсухайт-Ганцмод боомтоор нүүрс тээвэрлэн гаргаж буй автомашины тоо 11-р сарын 23-нд 211 байсан бол түүний дараа 10 хүрэхгүй болж буурсан байна. БНХАУ-ын тал Монголын жолооч нарыг “COVID-19”-ийн шинжилгээ өгөхийг шаардаж байгаа юм.

Хэдий тийм боловч зарим жолооч шинжилгээний бичгийг хуурамчаар үйлдсэн нь баригдсан учир БНХАУ-ын тал хяналтаа илүү чангатгасан нь гаалийн бүрдүүлэлт хийх үйл явцыг удаашруулсан талаар “sxcoal.com” мэдээллээ.

Гашуунсухайт боомтоор Монголын нүүрсний экспортын талаас илүү хувийг гаргадаг. Одоогоор Тавантолгой-Цагаан хад чиглэлд тээвэр хэвийн үргэлжилж байна. Харин Цагаан хад-Гашуунсухайт чиглэлийн богинын тээвэрт саатал үүсжээ.



11-р сарын 25 буюу Лхагва гарагийн байдлаар “Fenwei Energy”-ийн тооцон гаргадаг Монголын угаасан коксжих нүүрсний үнийн индекс тонн тутамдаа долоо хоногийн өмнөхөөс 20 юаниар өсөж, 1,080 юань болсон байна. Харин түүхий нүүрсний үнэ 20 юаниар өсөж, 880 юань болжээ.

БНХАУ-ын дотоодод ч бас коксжих нүүрсний нийлүүлэлтэд хомсдол үүсээд байгаа аж. БНХАУ-д коксжих нүүрсний олборлолтоор тэргүүлэгч Шаньси мужийн голлох компаниуд хүхэрлэг чанар багатай коксжих нүүрснийхээ үнийг тонн тутамд нь 70-100 юаниар нэмснийг “SXCoal” мэдээллээ. Шаньси мужид нүүрсний уурхайнуудын аюулгүй ажиллагааг чангатгасан хатуу зохицуулалтыг 12-р сарын нэгнээс хэрэгжүүлэхээр болсон юм. Үүнээс үүдэж ойрын хугацаанд нийлүүлэлт багасаж магадгүй гэсэн болгоомжлол бий болжээ.

Мөн гадаад зах зээл талаасаа Австралийн коксжих нүүрсний импортыг хязгаарласан хэвээр байна. БНХАУ-ын зарим гол худалдан авагч нь АНУ, Канадын нийлүүлэлтэд найдлага тавьж эхэлжээ. Хэдий тийм боловч хэмжээний хувьд хязгаарлагдмал хэвээр байгаа юм.

БНХАУ, Австралийн харилцаа хурцадсанаар 500 сая ам.долларын нүүрсний тээвэр саатаад байгаа юм. Ачаа тээврийн 50 гаруй хөлөг онгоц дөрвөн долоо хоногос дээш хугацаагаар хүлээж байгаа ажээ. Эдгээрт 5.7 сая тонн нүүрс ачаатай байгааг “Kpler”-ийн тооцоо харуулжээ. Австралийн Ерөнхий сайд энэхүү мухардмал байдлыг намжаах гэж хичээсээр байна.

Эх сурвалж: BloombergTV.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.